



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 102/ШШ2019/00471

Улаанбаатар хот

Нэхэмжлэгчийн татгалзлыг баталж,
хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
З.Доржнамжин би

Нэхэмжлэгч:Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж,
Ньюмайнд Групп ХХКомпанийн байранд байрлах, регистрийн дугаар 5039754,
Лэндмн ББСБ, ХКомпанийн нэхэмжлэлтэй

Хариуцагч:Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, Голден Парк хороолол, ЭТӨЧ
гудамж 101 дүгээр байрны 254 тоотод оршин суух, регистрийн дугаар ЕЭ
85101171, Дуут овогт Ганбаатарын Сугирт холбогдох

86 050 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 2019 оны 1 дүгээр сарын 24-
ний өдөр хүлээн авч хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ, ХКомпани шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ:Г.Сугир
нь Монгол улсын иргэний хууль, банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж,
төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон өрийн хүсэлтийн дагуу
Лэндмн ББСБ ХК-тай 2017 оны 9 сарын 28-ны өдөр 27137 дугаартай цахим зээлийн
эрх нээх гэрээг байгуулсан билээ.Лэндмн ББСБ, ХКомпани зээлдэгч Г.Сугир лэндмн
аппликейшнээр дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2017 оны 9 сарын 28-ны өдөр
70 000 төгрөгийн зээлийг 2 000 төгрөгийн шимтгэлтэй, 7 хоногийн хугацаатай, 2017
оны 10 сарын 05-ны өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй олгож нийт 72 000 төгрөг
Г.Сугир Хаан банкны 5378027277 тоот дансанд шилжүүлсэн. Зээлдэгч нь зээлийн
гэрээний 4.2.2 заалтыг зөрчин, зээлийг хугацаанд эргэн төлөх үүргээ биелүүлээгүй
байна.Г.Сугир гэрээний үүргээ биелүүлэх, зээлээ төлөхийг удаа дараа шаардсан
боловч эргэн төлөлтийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа тул хариуцагч Г.Сугираас
үндсэн зээлийн төлбөр 70 000 төгрөг, зээлийн шимтгэл 2 000 төгрөгийг гаргуулах
хүсэлтэй байна.Иймд хариуцагч Г.Сугираас үндсэн зээлийн төлбөр 70 000 төгрөг
шимтгэл 2000 төгрөг, нотариатын үйлчилгээний төлбөр 14 050 төгрөг буюу нийт 86
050 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ, ХКомпани хариуцагч Г.Сугираас 86 050 төгрөг
гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Хариуцагч Г.Сугир нь 86 050 төгрөгийг төлсөний улмаас нэхэмжлэгч
байгууллага нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзаж байх тул

нэхэмжлэгчийн татгалзлыг баталж, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндэстэй байна.

Нэхэмжлэгч байгууллагын улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 4550 төгрөгийн 50 хувь болох 2275 төгрөгийг төсвийн орлогод үлдээж, үлдэх 2275 төгрөгийг төсвийн орлогоос гаргуулан нэхэмжлэгч Лэндм ББСБ, ХКомпанид олгож шийдвэрлэх нь зүйтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.2, 75 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Лэндмн ББСБ, ХКомпани нь Г.Сугираас 86 050 /наян зургаан мянга тавин/ төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5-д зааснаар төсвийн орлогоос 2275 /хоёр мянга хоёр зуун далан таван/ төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Лэндмн ББСБ, ХКомпанид олгосугай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-д зааснаар зохигчид давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг дурдсугай.

ШҮҮГЧ



З.ДОРЖНАМЖИН